


СӨБ - 4,5 нас

	Сэдэв	Зорилго
1	Түгжээг тайлсан нь	Дүрсүүдийн ялгааг ажиглаж, ойлгож мэдэх
2	Басарын хүзүүвч	Аливааг турших, юмсын том жижиг, урт богино хэмжээ, хатуу, зөөлөн шинж чанарыг таньж ойлгох
3	Өвлийн өнгө	Дөрвөн улирлын онцлогийг танин мэдэх
4	Арслантай авдар	Дүрслэн урлах, бүтээлч байдлыг дэмжих
5	Дүүлэн үнэгтэй танилцсан нь	Хүүхэд овог нэр, амьдарч буй газар нутгаа хэлж бусдад өөрийгөө танилцуулж сурах
6	Сармагчнуудыг тоолсон нь	Юмсыг тоолж, өнгө ялгаж сурах
7	"Хөөрөгний эрэлд"	Цаг хугацааны тухай ойлголтыг бататгах (өглөө, өдөр, орой, өчигдөр, өнөөдөр, маргааш)
8	Модыг аргадсан нь	Бусдын сэтгэл хөдлөлийг мэдрэх, ойлгох
9	Шинэ найзын эрэлд	Найз нөхдийн дунд үүссэн асуудлыг шийдвэрлэж сурах /муудалцах, гомдоосон бол уучлал гуйх, эвтэй найртай нөхөрлөх/
10	Унтамхай аалз	Хүмүүс хоорондын ялгаатай байдлыг ойлгож, хүндэтгэлтэй хандаж сурах
11	Анхаа бахархам үйл бүтээсэн нь	Ажил мэргэжлийн тухай мэдэх, ойлгох
12	Амттаны нууц	Бусдын хөдөлмөрийг ойлгож, талархсан сэтгэлээ илэрхийлж сурах
13	Ааруулын хамгаалагчид	Хүний бие эрхтэн, оюун ухааны ач холбогдлыг ойлгож мэдэх
14	Чихрийн мангасууд	Амттан хэтрүүлэн идэх нь хүний эрүүл мэндэд хортой болохыг ойлгож авах
15	Ойн савдгийн яриа	Цэвэр цэмцгэр, эмх цэгцтэй орчинд эрүүл амьдрах дадал, хэвшилд сурах
16	Дэндүү амттай хоол	Хүүхдэд өөрийгөө ойлгуулах, хийсэн үйлдлээ тайлбарлах боломж олгох
17	Шидэт үг	Сэтгэлийн хөдөлгөөн, байдлаа үгээр илэрхийлж, дуу хоолойн өнгө, үйл хөдлөл, хандлагаараа харуулах
18	Бодол уншсан нь	Санаа бодлоо бусдад ойлгуулах
19	Онцгой нүдний шил	Нүдний шил, сонсголын аппарат, таяг, тэргэнцэртэй хүүхэд бидэнтэй ижил гэдгийг ойлгуулах, тэдэнд хүндэтгэлтэй хандах
20	Шинэ мөрөөдөл	Олон үндэстэн өөр өөр хэлээр ярьдгийг ойлгох
21	Машинтай найз	Бусадтай найрсаг, нээлттэй харилцахыг ойлгуулах
22	Сайхан сэтгэл	Баяр хөөртэй яриа, уйтгарласан тухай сонсож, сэтгэл санааг тайвшруулах
23	Та битгий уурлаарай	Дүрэм журмыг дагаж мөрдөхийг ойлгох
24	Бууз идсэн нь	Томчуудын тусламжгүйгээр гар, шүдээ угаах. Ариун цэврийн цаас зөв хэрэглэх зэрэг зөв зуршлыг дэмжих
25	Баярлалаа, ээж ээ!	00 ерөөний дүрэм баримтлах
26	Дотуур хувцасны дүрэм	Хувийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, дотуур хувцасны дүрэм мэдэх
27	Тогоруу	Зааврын дагуу Алхах, үсрэх, харайх, шидэх зэрэг хөдөлгөөн гүйцэтгэхдээ биеийн тэнцвэрээ хадгалах үйлийг гүйцэтгэхэд сургах
28	Өвөөгийн ярьсан үлгэр	Үгийн утгыг ойлгох, хэрэглэх чадвар сургах
29	Том болохын нууц	Ойлгосон зүйлээ бүтэн өгүүлбэрээр тайлбарлах
30	Дуусдаггүй яагаадуд?	Хүүхдэд юмсын учир шалтгаан, холбоо хамаарлын талаар таамаглал дэвшүүлэх, туршиж үзэх, дүгнэж ярилцах боломж олгож хүүхдийн “Яагаад?” гэсэн асуултыг хөхиүлэн дэмжинэ, хариултыг хүүхэдтэй хамтран эрж олох
31	Бид чадлаа	Хүүхдүүд гэртээ, анги, туршлагын талбайд цэцэг, ургамал тарьж арчлан, өсөлт өөрчлөлтийг нь ажиглаж судлах, хүүхдэд олж мэдсэн, туршиж судалсан зүйлээ тэмдэглэх, ярилцах (Жишээ нь: Цаг агаарын өөрчлөлтийг тэмдэглэх хуанли бэлтгэж өгөх)
32	Бяцхан цурхайг аварсан нь	Хүмүүс байгальд болон орчиндоо эерэг, сөрөг хандаж буй байдал, түүний үр дагаврыг үлгэр, зохиол, бичлэг, зураг ашиглан танилцуулж ярилцах
33	Ахан дүүсийн баяр	Монгол үндэсний баяр ёслолын тухай ярилцах
34	Алаг мэлхий	Монгол ардын тоглоом наадгай тоглох
35	Худалчийн агуй	Тоолох, харьцуулах, хэмжих, дараалуулах, ангилах зэрэг үйл хийх
36	Том алхам	Төрөл бүрийн аргаар тоолох хэмжих, хэмжсэн зүйлээ тэмдэглэх, тооцоолох
37	Энхээгийн зүүлтний эрэлд	Өдөр тутмын үйл ажиллагааны явцад эд юмс, тэдгээрийн хэлбэр хэмжээ, шинж чанарын талаар асуух
38	Аялгуу үг хэлдэг	Өдөр бүр хүүхдэд дуу, хөгжим сонсох, хөгжмөөс төрсөн сэтгэгдлээ хуваалцах, дууг ганцаараа болон бусадтай дуулах, хөгжмийн ая, хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийх боломж олгох
39	Хамтдаа тоглоцгооё	Хөгжмийн аялгуунаас хүчиг (чанга, сул) ялган сонсоод алга ташиж илэрхийлэх
40	Дүүлэн үнэгээ дүрслэн зурсан нь	Үзсэн харсан зүйл болон өөрийн санаа бодлоо зургаар илэрхийлэх
41	Чихний хорхой	Биеийн бүтцийн нүдэнд харагдах хэсгүүдээ нэрлэж, ямар үүрэгтэй болох, хэрхэн хамгаалах зэргийг мэдэх
42	Дуусдаггүй маргааш	Маргааш бол дараа, хэзээ нэгэн цагт гэсэн үг биш. Цагийн юмыг цагт нь хийх, бусдад амласан амлалтаа биелүүлэх
43	Уралдаанч хүүхдүүд	Хосоор хамтран ажиллаж, бие биедээ харилцан тусалдаг байх
44	Навч бүхэн ургахыг хүсэн	Ургамал модыг хайрлан хамгаалж, тарьж ургуулах, ил задгай хог хаяхгүй байх
45	Хундан хурга	Монгол ёс заншлаа аав ээж, өвөө эмээ нараасаа асуух, дагаж мөрдөх
46	Шидэт зүүлт	Бусдад туслахын сайн сайхныг мэдрэх, талархах





БАГА БОЛОВСРОЛ – 1,2-Р АНГИ

	Сэдэв	Зорилго
1	Үймээний эзэн хэн бэ?	Өөрийн хичээлийн хэрэглэлээ нэрлэж, үүрэг зориулалтаар ялган таних
2	Дөрвөн улирлын эх орон	Жилийн 4 улирал тус бүрд хамаарах саруудыг нэрлэж, улирлын ялгааг харьцуулах
3	Үнэнч хүүгийн үлгэр	Эхийн агуулгаас гол ба туслах дүрийн онцлогийг тодорхойлж, зургаар илэрхийлэх
4	Ногоон цэцгийн баглаа	Мэдээлэл технологийн хэрэгслийг зөв зохистой хэрэглэх
5	Зуслангийн найзууд	Гэр, сургуулийнхаа болон аймаг, сум, хот, дүүргийнхээ нэр, хаяг, байршлыг зөв хэлж чаддагаа харуулах
6	Мэргэн санаа	Арвын бүтэц хэрэглэн тоог цээжээр нэмэх, хасах
7	Хэдэн бууз хийсэн бэ?	Тоог нэгжээр, 10, 100-аар нэмэгдүүлэн, хорогдуулан тоолж сурах
8	Нууц нь юу вэ?	Хичээлээ анхааралтай, зөв сэтгэлээр сонсож өөрийн болгон эзэмшиж сурна.
9	Дэлхийгээ би мэднэ	Дууны утга санааг ойлгож, үгийг тод, зөв хуваарилж дуулж сурна.
10	Бамбаруушийн марш	4/2 буюу маршийн хэмнэлийг ойлгож, хөдөлгөөнөө зохицуулж сурна.
11	Хургаа хариулсан нь	Мэндлэх ёсны төрөл ялгааг мэдэж зөв мэндэлж сурах
12	Сайханд хүрэх зам	Эелдэг зөөлөн бусдад тустай үнэн үг хэлэхийн ач тусыг мэдэх
13	Зугаалга	Ахмад хүний үг сургаалыг сонсох
14	Багш, та!	Багшийг дээдлэх учир шалтгаан, ач тусыг мэдэх
15	Талархах мэдрэмж	Бусдад талархлаа зөв илэрхийлж сурах
16	Ойд төөрсөн найзууд	Тоглоомын зааврыг уншиж ойлгон зааврын дагуу тоглож сурах
17	Хамгийн сайхан ажил	Хүмүүсийн ажил хөдөлмөрийн онцлогийг танин мэдэх
18	Бусдын тус багаддаггүй	Бусдаас тусламж хүсэх чадвар эзэмших
19	Тусламжийн утас	Шаардлагатай үед ойр дотнын хүмүүс болон орон нутаг дахь яаралтай тусламжийн утасны дугаар (101, 102, 103, 107)-аас зөвийг сонгон, гэрийн хаяг, байршлын талаар үнэн зөв мэдээлэл өгөх, тусламж хүсэхэд суралцах
20	Хөгжимчин Анхаа	Дуу чимээ эрүүл мэндэд эерэг болон сөрөг нөлөө үзүүлж болохыг мэдэх, өөрийн эрүүл мэнд, аюулгүй байдалдаа анхаарах
21	Миний авга ах	Гэр бүлийнхнээ нэрлэх, 3 үеэ танилцуулах тэднийг хүндэтгэх
22	Нар ингэж ярив	Цаг агаарыг урьдчилан шинжих аргуудаас мэдэх, цаг агаарын мэдээний зураг тэмдэглэгээг ойлгож өдөр тутмын үйл ажиллагаа болон хувцаслалтаа тохируулж зохицуулах чадвартай болох
23	Хэрэмний үүрэнд зочилсон нь	Амьтдын амьдрах орчны ялгаатай байдал, тэдгээрт үзүүлэх хүний үйл ажиллагааны нөлөөг ойлгох, эерэг үйл хийх эрмэлзэлтэй болох
24	Нэг хуудас нэг мод	Модны ашиг тусыг ухаарч, модоо хайрлан хамгаалахад оруулж болох хувь нэмрээ тодорхойлох
25	Ус, газар, тэнгэрээр аялсан нь	Аливаа юмсын шинж чанарыг сайтар ажиглаж, учир шалтгааныг ойлгох /"Логик сэтгэх"-тэй холбоотой ч амьтны толгой, хөлийн тоотой холбоотой бодлого боддог тухай туссан байна./
26	Алдаагаа ухаарсан нь	Техник технологийн зөв, зохистой хэрэглээнд сурах /Өөрийн оюун ухаанаар бус компьютерийн бэлэн программ ашиглан хичээлээ хийсэн тухай/
27	Илбийн дугуйлангаас ирсэн захидал	Хичээл дээр сурсан зүйлээ өдөр тутмын амьдралдаа ашиглаж сурах /бараа худалдан авахдаа тоо бодох тухай/
28	Сэтгэлээсээ барьсан үүр	Эхлүүлсэн ажлаа дуустал сэтгэлээсээ хийх нь чухал болохыг ойлгох
29	Хөгжимтэй танилцсан нь	Хөгжмийн ач тусыг танин мэдэх
30	Үгийн шид	Бусадтай хүндэтгэлтэй харилцах, гомдоосон бол уучлалт гуйж сурах
31	Бөмбөлгөн бүрхүүл	Асуудлыг шийдвэрлэхдээ учир шалтгааныг олох, бусдын эд зүйлийг авахдаа зөвшөөрөл авч сурах
32	Анхаа шинэ найзтай болсон нь	Бусдын ялгаатай байдлыг ойлгох, хүн бүр харилцан адилгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх
33	Зохион бүтээгчтэй уулзсан нь	Эрэгтэй, эмэгтэй байх нь ажил мэргэжлээ сонгоход чухал биш, харин хүсэл мөрөөдөл, хичээл зүтгэл чухал болохыг ойлгох
34	Эрүүл биед саруул ухаан	Дасгал хөдөлгөөний ач тусыг ойлгох
35	Өвчнөөс хамгаалах нь	Амьсгалын замын халдварт өвчний тухай ойлгох, урьдчилан сэргийлэх
36	Өөрийгөө болон бусдыг хамгаалах нь	Онцгой байдал, хөл хорионы тухай ойлгох
37	Монгол гэр	Монгол гэрийн бүтэц, онцлогийг мэдэж авах
38	Газар эх	Хүний буруутай үйлдэл нь байгаль орчин, ан амьтдад сөргөөр нөлөөлдөг болохыг ойлгох
39	Усны дагинын нулимс	Усаа хайрлаж гамнах, гол ус бохирдуулж болохгүйг ойлгох
40	Өдрийн дэглэм мөрдөгчөө	Өглөө бүр дасгал хийх, өдөр тутам цаг агаарын байдлыг хуанлид тэмдэглэх зэрэг давтагдсан үйл ажиллагаа зохион байгуулж, хүүхдийн цаг хугацааны ойлголтод дэмжлэг үзүүлэх
41	Үндэстэн бүхэн үлгэр домогтой	Би Монгол хүн гэж бахархал төрүүлэх
42	Зүүдэндээ ухаарсан нь	Орон нутагтаа ургадаг хүнсний ногоо болон жимс, жимсгэнэ, тэдгээрийг ялгах, ашиг тусыг ойлгох
43	Хэн авсан бэ?	Дуу чимээг ялган таних
44	Соотон	Бусдын сэтгэл санааны байдлыг мэдрэх, ойлгох

